

МОНГОЛЫН ФЕОДАЛЫН НЭГДСЭН УЛСЫН ГАДААД ХАРИЛЦАА, ДИПЛОМАТЫН ТҮҮХЭЭС

Ж. БОР

XIII зууны эхээр Монголд феодалын нэгдсэн төр улс тогтсон нь урьдын олон жижиг улс ханлигуудын тархай бутархай байдлыг эцэс болгож, тэдгээрийн «улс төр, эдийн засаг, оюун сэтгэлийн хүчин чадлыг нягтруулан нэгтгэж чадсанаас гадна урьд нь тус тусдаа зөвхөн хөрш зэргэлдээ улс оронтойгоо алдаг оног харилцаж байсан явдлыг төгсгөл болгосон»¹ тухай манай түүхчид тэмдэглэжээ.

Монголын эзэнт улс нь үүсэн тогтсон цаг мөчөөсөө эхлэн төрийн гадаад бодлогодоо юуны түрүүнд хөрш зэргэлдээ улс орнуудтайгаа улс төр, эдийн засгийн харилцаа тогтоохыг хичээсэн байна. Гэтэл Монголын айл зэргэлдээ орших Алтан улс зэрэг зарим улс гүрэн шинээр тулгар Тогтсон Монгол улсыг хүлээн зөвшөөрч найртай харилцаа тогтоохын оронд урьдын тархай бутархай хэвээр нь байлгах бодлого баримталж ялангуяа хятадын эрх баригч феодалууд аль нэг хэлбэрээр дайсагнах явуулга хийж байв. Учир иймд Монгол улс, Алтан улстай харилцахдаа улс төр, цэргийн бодлогыг сөргүүлэн тавихад хүргэсэн юм. Гэтэл Чингэс тэргүүтэй Монголын феодалууд гадагш харилцах тэрхүү зайлшгүй шаардлагыг эзлэн түрэмгийлэх эрмэлзлэлдээ ашиглаж, дэлхийн олон улс орныг гал мэсээр түйвээсэн гамшигт дайн үүсгэхийн нэг шалтаг болгосныг дурдах нь зүйтэй.

Гэвч Монголчуудаас төр улсаа сахин хамгаалах, мөн бусад улсын газар нутаг лугаа явуулсан аян дайны амжилтын учрыг гагцхүү цэрэг дайны хүчээр тайлбарлавал учир дутагдалтай болно. Түүний нэгэн гол эх сурвалж нь Монголын төрийн идэвхитэй гадаад бодлого байлаа. Аль нэг харь «улсыг байлдан дагуулах дайныг явуулахдаа бусад орнуудтай найрамдалт хөршийн бодлого барьж, элч төлөөлөгчдөө тэдэнд зарж, найрамдах ба худалдаа хийхийг хүсэмжлэн, улмаар өөртэйгээ холбоо харилцаатай болгохыг»² хичээдэг байсан зэрэг нь тэдний гадаад бодлогын нэг арга хэлбэр болж байв. Ийм аргаар бусад улс орны анхаарлыг өөрийн зорилгоос холдуулан өөр зүйлд хандуулж, цэрэг, улс төр, дипломатын эсрэг арга хэмжээ авч ямарваа нэг саад хийхээс урьдчилан сэргийлж, зорьсон улсаа байлдан дагуулах боломж бий болгодог байв. Ингэж ямарваа нэгэн гадаад арга хэмжээг явуулахын өмнө дипломатын хувьд сайтар бэлтгэж өөртөө ашигтай нөхцлийг бий болгодог байжээ.

Мөн элчин төлөөлөгчдөд илгээх, худалдаа арилжааг хийхдээ тагнан турших эчнээ зорилгыг давхар тавьж, тэр улсын цэрэг, эдийн засгийн тухай мэдээг цуглуулан олохыг хичээж байсан нь бас л эцсийн бүлэгт Монголын феодалуудын түрэмгийлэн эзлэх бодлогын үргэлжлэл байлаа.

Байлдан дагуулахын өмнө ийнхүү тагнан турших урьдчилсан арга хэмжээ авч тэр улсын дотоодод ашиглаж болох ашигтай ямар нөхцлүүд буйг мэдэж, хялбараар эзэлж авах аргыг эрэлхийлдэг байсан нь түрэмгийлэн эзлэхийн бас нэгэн сурвалж болж байв. Монголын феодалын нэгдсэн улс ба түүний байлдан дагуулын үр дүнд тогтсон эзэнт гүрний тө-

1. Д. Хүүхэнбаатар, Монгол гүрний элчин харилцаа, УБ. 1964. 10-р тал

2. Мөн тэнд.

рийн гадаад бодлого дээр дурдсан үндсэн зүйлүүдээр тодорхойлогдож, олон арван жилийн турш хатуу баримтлагдсаар иржээ.

Гэвч аажимдаа Монголын их гүрэн хэд хэдэн биеэ даасан хаант улсууд болон задарснаас гадаад бодлого нь бас өөр өөр болжээ. Гэхдээ харь орнуудад очиж суусан Монгол хаад Чингисийн үеэс үүсгэн явуулж агсан гадаад бодлого, дипломатын арга ажиллагааны ёс журмыг хатуу журамлан тус тусынхаа захиран буй улсын гадаад харилцааны хэргийг хөтлөн явуулж байв.

Дундад зууны үеийн Монголын гадаад харилцаанд тэр үед манай нутагт оршин тогтнож байсан Монголын феодалын нэгдсэн төр, эзэнт гүрний (Юан улсын гадаад бодлого, дипломат харилцааны асуудал гол суурийг эзэлнэ. Чингисийн үеэс үүсгэн явуулсан дипломат бодлогыг Монголын их гүрний хаад идэвхтэй үргэлжлүүлэн явуулж, тухайн цаг үеийн улс хоорондын харилцааны асуудлыг хэлэлцэх зорилгоор дэлхийн олон улс оронтой элч төлөөлөгч солилцох болжээ.

Юан гүрний үед «Өрнө дахинтай шууд харилцахыг нилээд оролдож байсан боловч тэр бодлогыг»³ үнэн хэрэг дээр Ил хаадын улсаар дамжуулан явуулж байлаа. Харин Азийн улсуудтай Юан гүрэн шууд харилцаж байжээ. Юан гүрнээс Төвд, Аннам, Бирм, Кокхин, Япон зэрэг Азийн их бага улсуудтай цэрэг улс төр, соёлын болон эдийн засгийн хэлхээ холбоо тогтооход дипломат бодлого нь чиглэгдэж байсан боловч тухайн байдлаас шалтгаалан феодалын эзэнт улсын эрх ашигт үйлчилж улс хоорондын маргааныг цэрэг дайны аргаар шийдвэрлэж байсан нь нэг бус удаа билээ. Гэхдээ Монголын феодалын нэгдсэн төр, улсаас явуулж байсан гадаад бодлого, дипломат харилцааны «бүх үйл ажиллагаа жинхэнэ Монгол нутгийг хамаарч, Монгол дахь нэгэн төвөөс чиглэгдсэн гүйцэтгэгдэж байсан байна».⁴

Монголчууд эрт үеэс тогтсон Элчин харилдааны өв уламжлалтай байсан бөгөөд түүнийгээ төрийн гадаад бодлогодоо ашиглан хөгжүүлж арга барил, хэлбэрийг нь улам боловсронгуй болгож байв. Монголд феодалын нэгдсэн төр улс тогтсон тэр үеэс Монгол улсын гадаад харилцаа өргөнжиж, Дорно ба өрнө дахины олон улс оронтой улс төр, эдийн засаг, соёл, шашны нилээд өргөн дэлгэр харилцаа тогтоож эхэлсэн юм. Тиймээс Монгол улстай айл зэргэлдээ буюу эртнээс эдийн засаг, соёлын харилцаатай байсан улс орнууд Монголын тухай үнэн зөв бөгөөд өөртөө хэрэгтэй мэдээг олж авахыг эрмэлзэж байлаа. Энэхүү зорилгоор Монголд элч төлөөлөгчдөө «илгээж харилцаа тогтоохын хамт түүний улс төр, цэрэг, эдийн засгийн мэдээг хураах, Монгол улсыг дайсагнах буюу ямар нэгэн цэргийн холбоонд нөхөр хань татах, шашин суртахууныг дэлгэрүүлэх, худалдаа арилжаа хийх»⁵ бодлого явуулж байжээ. Ийнхүү тэр үеийн дэлхий дахины нөлөө бүхий улс орнууд Монголын хаадтай харилцах болсон нь үнэн хэрэгтээ Монголын төрийг хүлээн зөвшөөрсөн хэрэг байв. Нөгөө талаар тэр үед дэлхийн нэлээд олон улс орныг эрх нөлөөндөө авч Дорно ба Өрнийн хэрэгт ихээхэн эрх мэдэл бүхий болсон Монгол гүрний оролцоогүйгээр олон улсын харилцааны ямарваа нэгэн асуудлыг шийдвэрлэх, тэр зүгээс ямар хандлага байгааг харгалзан үзэхгүйгээр улс хоорондын харилцааг байгуулах нь бэрхтэй болж байв. Монголын байлдан дагуулалт газар авах тутам урьд нь үл мэдэх олон улс оронтой тулгаран тэдэнтэй харилцах элчин харилцаа нь улам өргөжиж

3. БНМАУ-ын түүх. I боть. УБ. 1966. 377-р тал.

4. Мөн тэнд 373-р тал

5. Хүүхэнбаатар, Монгол гүрний элчин харилцаа. 1964. 10-р тал.

байлаа. Түүхийн ба элчин харилцааны баримтаас үзвэл Монгол улсаас харь орнуудад зарагдаж буй элчин нь тусгай мэргэжлийн хүн байснаас гадна тэднийг ангилах дипломатын дэв зэрэг бас байжээ. Элчингийн язгуур гарал, хэргэм тушаал, гүйцэтгэх үүргийн цар хүрээ зэргээс шалтгаалан доорхи дэв зэрэгт хувааж байв. Үүнд:

Бүрэн эрхт дипломат элчин, төлөөний элч, элч, элч-худалдаачин гэх мэт. Эдгээр элч төлөөлөгч нарыг харь оронд түр хугацаагаар тодорхой үүргийг гүйцэтгүүлэхээр илгээдэг байсан нь даруй феодалын нийгэм дахь элчин харилцааны онцлог мөн. Энэ онцлог нь зөвхөн Монгол дахь феодалын төр улс элчин харилцааны онцлог бус дэлхийн феодалын нийгмийн хүрээнд нийтлэг оршиж агсан онцлог юм.

Харь оронд зарагдаж буй элч нар нь хааны зарлигаар тохоон томилогдож гагцхүү түүний нэрийн өмнөөс төлөөлөн очиж байсан тул элчингийн дэв зэргээсээ шалтгаалахгүйгээр бүгд «зарлигийн элч» хэмээх ерөнхийлсөн нэрээр нэрийдэж байв. Гэхдээ элч нь гүйцэтгэх үүргийн цар хүрээ, дэв зэргээсээ хамааран эрх хэмжээ, ямба цолыг баталсан алт, мөнгө, хүрэл, модон пайзтай илгээгддэг байжээ. Алтан пайзтай элчин бол онц эрхтэй элч юм. Түүний онц эрхийн тухай Дорно ба Өрнө дахины судар түүхэнд багагүй тэмдэглэн үлдээсэн байдаг. «Алтан пайзтай элч юу дуртайгаа тушааж болох ба тушаасан бүхнийг нь даруй саадгүй биелүүлнэ»⁶ гэж Гильом Рубрик бичжээ. «Алтан пайзтай Монгол элч нарыг алтан пайзтан (Сэр иг па) гэж нэрлэн Монголын хааны онгон эрх ямба бүхий бие төлөөлөгч болохыг тодорхойлон зааж тэдэнд аль болохоор их бэлэг сэлтийг барьж тал засаж байхын чухлыг онцлон заасан мэдээ баримт төвд сурвалж бичгүүдэд мөн байдаг».⁷

Монголын феодалууд харь оронд элчин төлөөлөгч довтолгохдоо тэр газрын байдлыг заншилан мэдэх ичнээ зорилгыг бас давхар тавьж энэ зорилгоо биелүүлэхийн тулд нэвтрэхэд дөхөмтэйг харгалзан худалдаачдыг элчин харилцаанд өргөн ашиглаж байв.

Эдгээрээс үзэхэд XIII-XIV зууны Монгол улсын элчин харилцаа нь харь бусад оронтой дипломат ба эдийн засгийн харилцаа тогтоох, нөгөөтэйгүүр тэдний байдлыг заншилан мэдэх гэсэн хоёр талтайгаар хөгжиж байжээ.

Монголын феодалын нэгдсэн төрийн анхны хаад хийгээд тэдний залгамжлагчид элчин харилцааг төрийн «алтан аргамж»⁸ гадаад бодлогын чухал хэсэг гэж ихэд анхааран үзэж дипломатын урлагийг эзэмшүүлэх арга хэмжээ авч байсан нь Монголчуудын дипломат арга ажиллагааны нарийн төвөгтэй систем бий болгоход хүргэжээ.

Монголын хаадаас явуулж байсан төрийн бодлогод бусад орныг байлдан дагуулахдаа эн түрүүнд элч төлөөлөгч зарж эсэргүүцэн эс тэмцвээс газар нутаг, эд хөрөнгийг хамгаалан хадгална хэмээн ятган ухуулах, дипломатын ба цэргийн даралт шахалт үзүүлэх, эдийн засгийн хавчилт хийх, цэрэг, улс төрийн гэрээ байгуулж эвсэл холбоо тогтоох дотоодын хямрал, зөрчил тэмцлийг ашиглах, хооронд нь эвдрэлцүүлж хүчий нь барах, эцэст цэргийн хүч хэрэглэн эзлэн авах зэрэг нарийн арга ажиллагааг боловсруулан явуулж байсан байна. Монголын байлдан дагуулагчдаас явуулж байсан гадаад бодлого ба дипломат арга ажиллагааны гол шинж нь чухамхүү К. Марксын хэлсэнчлэн «нэг улсын дипломатын амжилт нь нөгөө улсын алдаан дээр тулгуурлаж байдаг»⁹ гэсэн зарчмын дагуу бүх ажиллагаа нь явагдаж байжээ.

6. Путешествия в Восточные страны Карпини и Рубрика. М. 1957. 145-р тал.

7. БНМАУ-ын түүх I боть. 360-р тал.

8. Монголын нууц товчоо. УБ. 1957, 254, 256-р зүйл.

9. К. Маркс, Ф. Энгельс. м. 1966. Соч. Боть 17. 278-р тал.

Дундад зууны үеийн Монгол улсад дипломат урлаг, ер нь гадаад харилцааны хэрэг нарийн болж байснаас гадна арга ажиллагаа нь олон талтай байлаа. Тухайлбал Алтан улсыг эзлэн авах явдалд эрэг зэвсгийн хүч хийгээд дипломат арга ажиллагаа нь нэгэн адил хэмжээний үүргийг гүйцэтгэсэн гэж хэлж болно.

Алтан улсыг эзлэх явдлыг дан цэрэг зэвсгийн хүчээр гүйцэтгээгүй, харин ч дипломат үйл ажиллагааны арга ихээхэн үүргийг гүйцэтгэсэн байна. Тухайлбал Сүн улсыг хатган Хэнань мужаар дэнчин тавьж, хүчийг нь ашиглах бодлого явуулж Алтан улсыг хоёр талаас нь хавчин ганцаардуулж байлдсаар мөхөөжээ. Мөн байлдаж бүхий үедээ хоёр удаа найрамдлын гэрээ байгуулсан нь байлдан эзлэх бодлогоосоо ухарсандаа бус харин түр амсхийж хүчээ сэлбэн авах гэсэн цэвэр тактикийн зорилго бүхий дипломат ажиллагааны арга мэх байлаа. Харин «Байлдах бололцоотой байх үедээ найрамдах байгуулахыг эс зөвшөөрч найрамдъя хэмээсэн Алтан улсын саналыг хүлээн авахаас татгалзаж»¹⁰ байжээ.

Мөн дипломат сүрдүүлэг, авхаалж самбааг хослуулан хэрэглэж Сартуул (Хорезм) улсаас Хятадын талаар баримталж байсан бодлогыг Алтан улсаас холдуулж чадсан байна. Монголын феодалууд ийнхүү гадаад харилцааныхаа зорилгод хүрэхийн тулд улс төр, эдийн засаг, шашны харилцааг идэвхжүүлж, дипломат аргаас эхлэн цэрэг зэвсгийн хүчээр түрэмгийлэн орох хүртэлх бүх хэлбэрийг ашиглаж байв.

Ялангуяа XIII-XIV зууны үед Монгол улсын гадаад харилцаа тэр дундаас элчин харилцаа өргөн далайцтайгаар тэлж, дипломатын урлаг, арга ажиллагаа хөгжин боловсорч агсан хэдий ч энэ нь Монголын тус гаар тогтнолыг бататгах, тэгш эрхт дипломат харилцааг бусад орон лугаа тогтоон барихад чиглэгдсэн бус харин бусдын газар нутгийг түрэмгийлэн эзлэх хэмээсэн эзэрхэг дайны бодлоготой нягт уялдаатай гарч байсныг цохон тэмдэглүүштэй. «Их гүрний үед алс холын харь орнуудад зарагдан явдаг тусгай мэргэжсэн элч нарын эрх үүрэг үлэмж»¹¹ нэмэгджээ. «Ямар элчийг хичнээнээр нь хаацаа ч явуулсан тэдэнд улаа унаа унд хүнсийг саадгүй гарган өгч хэрэглүүлэх ёстой ажээ. Мөн түүнчлэн гаднын ямар ч орноос элч зарлага ирсэн тэдэнд унаа хөсөг, хоол ундыг гаргаж өгөх ёстой»¹² хэмээн Плано Карпини бичсэн байна.

Энэ нь эртний Монголчууд элчин харилцааг ихэд онцлон үзэж байсны нотолгоо юм. Элчин харилцааг хөгжүүлэхэд их гүрний хэмжээгээр байгуулсан өртөө ихээхэн ач холбогдолтой байсныг дээрх зүйл харуулж байна.

Чингэсийн дараах хаадаас Ази, Европын олон улс орныг түрэмгийлэн эзэлж Хархорум төвтэй феодалын эзэнт гүрнийг байгуулсан нь Хар хорум хотын алдар цууг хол ойрд түгээж харь олон улсын элч төлөөлөгчид, худалдаачдын хуран цуглардаг газар болжээ.

Монголын их гүрний улс төрийн төв «Хархорумд Никей, Түрэгийн султан, Энэтхэг, Халифийн элчид,¹³ Хятадын Сун улс, Солонгос, Их Армен, Орос, Франц зэрэг олон улс болон Ромын тагын элчин төлөөлөгчид¹⁴ хүрэлцэн ирж Монгол хаадтай хэлэлцээ хийж байжээ. Гүюгийг Монголын их хаанд «Өргөмжлөх ёслолд гаднын 4 мянга гаруй элч, төлөөлөгчид оролцож»¹⁵ байсан мэдээ бий.

10. К. Бичурин, История первых четырех ханов дома Чингиса, СП5, 1829 43-р

11. БНМАУ-ын түүх I боть. 360-р тал

12. Путешествия в Восточные страны 45-р тал.

13. Мөн тэнд

14. БНМАУ-ын түүх I боть. 367-р тал

15. Мөн тэнд 367-р тал.

Дундад зууны үеийн Монголчуудын дипломатын гол арга ажиллагаа нь харь орнуудын хоорондын зөрчил тэмцлийг дэвэргэн ашиглаж нэгийг нь нөгөөгийн эсрэг турхирах, эсвэл нэгэнтэй нь найрамдан хамсаж нөгөөг нь цохих, ийнхүү хүчийг нь ашигласны дараа холбоотон улсаа эргэн цохих, харь орнуудын эвсэл холбооны аюулыг өөрөөс зайлуулах явдалд оршиж байв. Энэхүү арга ажиллагаа нь Алтан улс, Хиргис, Уйгар, Хар Кидан, Хорезм, Тангад зэрэг улсуудыг байлдан дагуулахад зохих үр дүнгээ өгчээ. Дээрх улсууд хийгээд Солонгос, Төвд, Аннам, Бирм, Кохинхин зэргийг дагуулан авахад монголчууд цэргийн хүч хэрэглэхийн хажуугаар урьдчилан сайтар боловсруулсан дипломат бодлогыг явуулж дипломатын ашиг хонжоо олж байжээ.

Монголд дипломатын урлаг боловсорч гүнзгийрэхэд тэр үеийн эрдэм мэдлэгтэй зүтгэлтнүүд багагүй үүрэг гүйцэтгэж байсан бөгөөд харь улсын соёл, хэл, хэв заншил, ёс суртахуун, хууль дүрэм, газар нутгийг сайн мэдэх гадаадын хүмүүсийг авч ашиглаж байсан онцлогтой ажээ.

Монголын гадаад харилцаа ихээхэн өргөжиж, түүнтэй уялдан дипломатын урлаг гүнзгийрсэн нь дипломат бичгийн хэлбэр хэллэгт зүй ёсны нөлөө үзүүлсэн бөгөөд дипломат бичиг хөтлөх ёс арга барил, хэв заншил тогтоожээ. Тухайлбал, Монгол хаадын зарлиг, харь улсын хаадад илгээж байсан дипломат харилцааны албан бичигт «Мөнх тэнгэрийн хүчинд» гэсэн тогтмол, хэллэг байснаас гадна мөр тэтгэх, дарах ёс байв.

1289 онд ил хаан Аргунаас Францын гоо Филипп ванд илгээсэн хуучин Монгол бичгээр бичсэн захидалд гурван янзаар мөр өргөсөн байна. Үүнд: «Тэнгэр, «Хаан», «Аргун» гэсэн үгсийг хамгийн дээд мөрнөөс, Францын вангийн нэрийг доод мөрнөөс эхлэн бичсэн байв.¹⁶

Гадаад харилцааны албан хэргийг хөтөлдөг тусгай мэргэжлийн бичээч (бичэгч) хэмээх түшмэл хааны дэргэд ажиллаж дипломат бичгийг хөтлөн үйлдэж байжээ. Харь орнуудад явуулах бичиг захидлын үг, эхийг ихэнхдээ уйгаржин монголоор буюу дөрвөлжин үсгээр зохион үйлдэж уул орных нь хэлээр хавсралт хувь үйлдэж эцэст нь хаан гарын үсгээ зурж, төрийн тамга дардаг байжээ.¹⁷ Тухайлбал Плано Карпинийг нутаг буцахад Гүюг хааны зарлигаар Кадак, Чингай, Бала зэрэг их түшмэлүүд болон олон бичээч нар Ромын пап ламд илгээх бичгийг зохион найруулж, уул бичгийн үг бүрийг Плано Карпинид тайлбарлан өгч латин хэлээр орчуулаад олон удаа уншуулан тулгаж хянасны дараагаар мөнхүү бичгийг бас сарацин (перс)-аар орчуулсан бичиг хавсарган илгээсэн байна.¹⁸ Энд нэгэн зүйлийг тодруулахад хааны бичиг, зарлиг, захидалд дардаг улаан тамга, хөх тамга, гарын тамга гэсэн гурван янзын тамга байсан байна. Тэр нь эдгээр бичгийн хууль эрхийн ба дипломатын ач холбогдлоос шалтгаалж янз янзын тамга дардаг байсных бизээ.

Дээр өгүүлсэн бичигт Гүюг хаан Ромын пап ламаас «Монгол хааныг христос шашинд орохыг шаардаж, монголчууд мажаруудыг болон христос шүтлэгтнийг эзэлсэн явдлыг их гайхан алдаа эндүүрэл болов уу»¹⁹ гэснийг догшин үгээр эрс няцааж, дагаж орохыг шаардаж «...одоо та нар иргэн чинь болж эд орга бүхнээ өгье хэмээн үг өгүүлбээс зохино»²⁰ гэж бичжээ. Ер нь Монголын хаад бусад улс орныг доордод үздэг гэм

16. A. Mostacrt. F W. Cleaves, The Letters of 1289 to 1305 of ilkhan Argun or oljeitü to Philippe de Bel. Cambridge. Massachusetts, 1962. p. 17—18,

17. Ч. Далай. Юан гүрний үеийн Монгол, УБ, 1973, 83-р тал

18. Плано Карпини 79-р тал.

19. БНМАУ-ын түүх I боть 369-р тал

20. Мөн тэнд

«мэдтүгэй» гэдэг илгээлт бичгийнх нь хэлбэрээс ч харагддаг юм. Тухайлбал, франкийн хааны элч Рубрикийг буцахад нь IX Людовикэд Мөнх хаанаас илгээсэн бичигт ч тийм аяс илт байдаг.

XIII-XIV зууны үеийн монголчуудын гадаад харилцааны үйл ажиллагаанд гэрээ хэлэлцээр байгуулах явдал томоохон суурийг эзэлж байсан байна. Тэд гэрээ хэлэлцээрийг байгуулахдаа тухайн үеийн олон улсын харилцаанд нийтээр баримталж байсан ёс журам, хэм хэмжээ, заншлыг дагаж мөрдөж байсны ул мөр монголын феодалын нэгдсэн улс ба эзэнт гүрнээс гадаад улс оронтой байгуулж байсан гэрээ хэлэлцээрт тусгагдан үлджээ. Ялангуяа Монголын их гүрний үед бичмэл хэлбэрээр байгуулсан гэрээний эхийг ихэвчлэн уйгаржин монгол буюу дөрвөлжин үсгээр зохион үйлдэж, мөн нэгэн адил эх гэрээг хамтран байгуулагч орны хэлээр үйлдэж тус тусдаа хадгалан мөрдөх журамтай байжээ.

Монголын их гүрний үед харь улс орнуудтай гэрээ хэлэлцээр байгуулах явдал үлэмж болсон бөгөөд тэдгээр гэрээ хэлэлцээрийн утга санааг Монголын феодалууд өөрсдийнхөө ашиг сонирхолд бүрэн нийцүүлж байв. Тухайлбал 1245 онд Түрэгийн султан хаантай байгуулсан гэрээ ний дагуу Түрэг нь жил бүр асар их хэмжээний мөнгөн алба, мал хөрөнгийг Монголын хаанд өргөж байх үүрэг авч байжээ.²¹

1242 онд Монгол цэрэг Кавказыг эзлэн Армены Килик улсын хилд ойртон очиход Киликийн феодалууд яаралтай элч зарж Монгол цэргийн жанжин Байжу ноёнтон хэлэлцээр хийжээ. 1242 оны Монгол, Киликийн хэлэлцээрийн дагуу Килик нь нэлээд биеэ даасан эрхтэй түшмэг улс болсноос гадна хоёр улс бие биендээ харилцан цэрэг зэвсгийн тусламж үзүүлж байхаар тохиролцсон байна.

1258 онд Армены ван II Гетум Хархорумд ирж Мөнх хаантай хэлэлцээр хийсний дүнд Монгол Армены гэрээ байгуулагджээ. Энэхүү гэрээ нь нийт долоон зүйлээс бүрэлдэж байв. Эдгээр нь «Мөнх хааныг бүх албатуудынхаа хамт христос шашинд орох, христос шашинтан ба Монголчуудын хооронд мөнхийн найрамдал нөхөрлөл тогтоох, монголчуудын эзэлсэн ба ирээдүйд эзлэх газар оронд христос шашны сүм хийд, лам нарыг алба гувчуураас чөлөөлөх, христосын шарил байдаг ариун газрыг сарацин нараас чөлөөлж христос шашинтанд эргүүлж өгөх, лалын эсэргүү шашины толгой Багдадын халифын эсрэг дайтах, Монголын бүх хаадын, нэн ялангуяа Арментай ойр зэргэлдээ Монгол хаадын улсаас цэргийн тусламжийг хэрэгтэй цагт яаралтай үзүүлж байх, сарацин нарын эзлэн авсан ба Монголын эрхшээлд орсон Армены газар нутгийг эргүүлж өгөх,²² зэрэг болно.

Гэрээний байдлаас үзэхэд Армен нь Монгол ба ойрх Дорнодын харилцааны замд чухал байр суурь эзэлж байсан учир Монголын феодалууд Арменыг эрх нөлөөндөө барьж, цэргийн хүч, газар нутгийг нь ашиглах зорилгоор дипломатын хувьд төдий л их алдагдалгүй буулт хийжээ.

21. БНМАУ-ын түүх. I боть. 367-р тал.

22. Армянские источники о Монголах. М., 1962. 68-р тал